БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хангал сумын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код: БУА-2021 /81/-СТА-ТШ3**


Цахим хуудас: www.audit.mn
Булган аймаг
2021 он

Тэргүүлэх аудитор: Д.Анхбаяр
Утас: 70342580
Цахим хаяг: Ankhbayard@audit.gov.mn
Аудитын менежер: Ж.Энхцоодол
Утас: 70342716
Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn
Аудитор: П.Содном
Утас: 70342495
Цахим хаяг:Sodnomp@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

## Агуулга


1.Төрийн аудитын санал, дүгнэлт ....3

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан....3

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ....3

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ....4

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан....6

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ....9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ....9

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан ....11

3. Аудитын тайлан....12

3.1. Ерөнхий зүйл....12

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй ....12

3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт ....12

3.4. Материаллаг байдал ....12

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд ....13

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт ....13

3.7. Шилэн дансны мэдээлэл....14

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ....14

3.9. Аудитын илрүүлэлт....15

Залруулсан алдаа....15

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил ....15

Аудитын зөвлөмж....15

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд ....15

4. Менежментийн захидал....16

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт ....**Error! Bookmark not defined.**

## 1.Төрийн аудитын санал, дүгнэлт

## Аудит хийсэн санхүүгийн тайлан
## 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **99,319,595.58** | **72,997,722.60** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 95,256,125.74 | 69,837,748.29 |
| **351** | **Түүхий эд материал** | 146,700.00 | 162,000.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | 146,700.00 | 162,000.00 |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | 2,081,800.00 | - |
| **354** | **Хангамжийн материал** | 84,927,625.74 | 62,025,748.29 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,253,900.00 | 1,086,900.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 7,240,860.00 | 7,005,810.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 9,288,000.00 | 486,000.00 |
| 35450 | Барилгын засварын материал | 22,218,775.00 | 4,817,550.00 |
| 35460 | Хүнсний материал | 474,996.25 | - |
| 35470 | Бусад хангамжийн материал | 44,451,094.49 | 48,629,488.29 |
| 35600 | Мал амьтад | 8,100,000.00 | 7,650,000.00 |
| **36** | **НӨӨЦИЙН БАРАА** | 4,063,469.84 | 3,159,974.31 |
| 36100 | Барааны нөөц | 1,226,860.34 | 1,226,860.34 |
| 36400 | Шатахууны нөөц | 1,609,780.00 | - |
| 36600 | Бусад нөөц | 1,226,829.50 | 1,933,113.97 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **599,048,604.19** | **599,625,103.98** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 599,048,604.19 | 599,625,103.98 |
| **392** | **Биет хөрөнгө** | 582,273,104.28 | 581,549,604.11 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,464,488,417.59 | 1,464,488,417.59 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (945,478,669.82) | (972,349,304.30) |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 16,255,900.00 | - |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (16,255,900.00) | - |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 51,146,843.00 | 63,953,902.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (21,481,774.91) | (25,071,021.55) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 111,475,660.16 | 97,766,916.20 |

| | | | |
|---|---|---|---|
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (83,741,384.09) | (53,206,085.33) |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 5,716,909.40 | 5,654,800.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | (5,644,676.55) | (5,564,800.00) |
| 39217 | Ном | 5,791,779.50 | 5,876,779.50 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 16,775,499.91 | 18,075,499.87 |
| 39301 | Програм хангамж | 250,000.00 | 1,600,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | (112,500.09) | (162,500.13) |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 16,638,000.00 | 16,638,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **698,368,199.77** | **672,622,826.58** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **698,368,199.77** | **672,622,826.58** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 698,368,199.77 | 672,622,826.58 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 208,288,145.66 | 208,288,145.66 |
| 51101 | Өмч: - төрийн | 208,288,145.66 | 208,288,145.66 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 84,449,312.18 | 29,161,432.99 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 84,449,312.18 | 84,449,312.18 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (55,287,879.19) |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 405,630,741.93 | 435,173,247.93 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **698,368,199.77** | **672,622,826.58** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **454,232,665.50** | **536,292,436.47** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **5,684,565.50** | **6,934,936.47** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 5,608,427.50 | 6,934,936.47 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 5,608,427.50 | 6,934,936.47 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,200.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,015,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 4,580,227.50 | 6,934,936.47 |
| **122** | **Тусламжийн орлого** | 76,138.00 | - |
| 122001 | Хандив тусламж /дотоод/ | 76,138.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **448,548,100.00** | **529,357,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 422,330,700.00 | 507,447,300.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 422,330,700.00 | 507,447,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 848,200.00 | 520,000.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 848,200.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 520,000.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,369,200.00 | 21,390,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,369,200.00 | 21,390,200.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **421,556,752.13** | **590,489,644.71** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **421,556,752.13** | **590,489,644.71** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 407,949,246.13 | 531,614,008.21 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 312,637,182.00 | 350,388,973.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,500,200.00 | 272,794,291.00 |
| 210102 | Нэмэгдэл | 54,625,100.00 | 47,036,944.00 |
| 210104 | Урамшуулал | 39,511,882.00 | 30,557,738.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,250,940.00 | 43,516,728.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,979,565.00 | 29,999,881.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,159,200.00 | 3,529,396.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,527,400.00 | 2,823,521.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 554,863.00 | 651,266.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,029,912.00 | 6,512,662.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 15,941,828.00 | 30,108,998.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 3,619,682.00 | 2,816,998.00 |
| 210302 | Түлш, халаалт | 11,217,000.00 | 26,452,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,105,146.00 | 840,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,966,986.00 | 9,345,286.20 |
| 210401 | Бичиг хэрэг | 424,466.00 | 353,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,252,022.00 | 2,856,580.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 90,000.00 | 280,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 71,460.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 80,000.00 | 440,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 211,000.00 | 5,078,200.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | 838,038.00 | 336,506.20 |
| **2105** | **Нормативт зардал** | 14,046,972.25 | 8,254,080.25 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 64,500.00 | 104,700.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210502 | Хоол, хүнс | 13,720,772.25 | 7,480,180.25 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 261,700.00 | 669,200.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 2,763,250.00 | 7,206,475.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,763,250.00 | 7,206,475.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 117,400.00 | 248,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 117,400.00 | 248,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 1,754,200.00 | 787,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,682,200.00 | 463,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 72,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,470,487.88 | 81,757,667.26 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,715,000.00 | 33,529,140.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,405,050.00 | 4,755,600.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 11,350,437.88 | 43,472,927.26 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 13,607,506.00 | 58,875,636.50 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 8,845,234.00 | 5,600,295.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,010,234.00 | 5,350,295.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 835,000.00 | 250,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,762,272.00 | 53,275,341.50 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,762,272.00 | 53,275,341.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **32,675,913.37** | **(54,197,208.24)** |
| **145** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН** | 5,375,000.00 | 5,490,000.00 |
| 145002 | Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны олз | 5,375,000.00 | 5,490,000.00 |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 4,274,105.70 | 6,580,670.95 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 4,274,105.70 | 6,580,670.95 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 1,100,894.30 | (1,090,670.95) |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **33,776,807.67** | **(55,287,879.19)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **448,548,100.00** | **529,357,500.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **848,200.00** | **-** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 848,200.00 | - |

| | | | |
|---|---|---|---|
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 848,200.00 | - |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 13,200.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 835,000.00 | - |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **447,699,900.00** | **529,357,500.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 422,330,700.00 | 507,447,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 422,330,700.00 | 507,447,300.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 520,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 520,000.00 |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 25,369,200.00 | 21,390,200.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 25,369,200.00 | 21,390,200.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **440,053,710.00** | **515,891,420.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **440,053,710.00** | **515,891,420.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **425,496,994.00** | **459,122,583.50** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 312,637,182.00 | 350,388,973.00 |
| 210101 | Үндсэн цалин | 218,500,200.00 | 272,794,291.00 |
| 210102 | Нэмэгдэл | 54,625,100.00 | 47,036,944.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 39,511,882.00 | 30,557,738.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 39,124,875.00 | 43,516,728.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 26,853,500.00 | 29,999,881.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,159,200.00 | 3,529,396.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,527,400.00 | 2,823,521.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 554,863.00 | 651,266.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,029,912.00 | 6,512,662.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 22,792,578.00 | 20,991,498.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,353,432.00 | 3,001,498.00 |
| 210302 | Түлш, халаалт | 16,825,000.00 | 17,150,000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1,614,146.00 | 840,000.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| 210305 | Ашиглалтын зардалд төлсөн /ТӨҮГ/ | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 16,571,575.00 | 4,306,000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 182,500.00 | 160,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,253,400.00 | 1,850,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 274,700.00 | 280,000.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210404 | Ном, хэвлэл | 151,500.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 214,400.00 | 580,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 12,495,075.00 | 1,436,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 12,193,354.00 | 7,497,584.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126,700.00 | 120,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 11,457,754.00 | 6,686,584.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 608,900.00 | 691,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 899,200.00 | 15,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 899,200.00 | 15,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 117,400.00 | 248,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 117,400.00 | 248,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,187,700.00 | 1,497,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,115,700.00 | 1,173,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 72,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 18,973,130.00 | 30,660,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 9,050,000.00 | 24,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,923,130.00 | 6,660,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,556,716.00** | **56,768,836.50** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 9,794,444.00 | 3,493,495.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 8,959,444.00 | 3,243,495.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 835,000.00 | 250,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 4,762,272.00 | 53,275,341.50 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 4,762,272.00 | 53,275,341.50 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **8,494,390.00** | **13,466,080.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **8,494,390.00** | **13,466,080.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **8,494,390.00** | **13,466,080.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 8,494,390.00 | 13,466,080.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | 6,078,390.00 | 12,031,080.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | 2,416,000.00 | 1,435,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **(8,494,390.00)** | **(13,466,080.00)** |
| **7** | **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **-** | **-** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | - |

| | | | |
|---|---|---|---|
| 9 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | - |
| 10 | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | - |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 208,288,145.66 | 405,630,741.93 | 84,449,312.18 | 698,368,199.77 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **208,288,145.66** | **405,630,741.93** | **84,449,312.18** | 698,368,199.77 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | - | - |
| C08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,288,145.66** | **405,630,741.93** | **84,449,312.18** | 698,368,199.77 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **208,288,145.66** | **405,630,741.93** | **84,449,312.18** | 698,368,199.77 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **208,288,145.66** | **405,630,741.93** | **84,449,312.18** | 698,368,199.77 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | 29,542,506.00 | - | 29,542,506.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (55,287,879.19) | (55,287,879.19) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **208,288,145.66** | **435,173,247.93** | **29,161,432.99** | 672,622,826.58 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 511570300.00 | 475985158.50 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 511570300.00 | 462519078.50 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 497535800.00 | 459025583.50 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 381475700.00 | 350388973.00 |
| 210101 | Үндсэн цалин | 268863000.00 | 272794291.00 |
| 210102 | Нэмэгдэл | 71865800.00 | 47036944.00 |
| 210104 | Урамшуулал | 40746900.00 | 30557738.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 51499200.00 | 43516728.50 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 36240100.00 | 29999881.66 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3814800.00 | 3529396.23 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3051800.00 | 2823521.27 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 763000.00 | 651266.40 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 7629500.00 | 6512662.94 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 24470000.00 | 20991498.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 5700000.00 | 3001498.00 |
| 210302 | Түлш, халаалт | 17150000.00 | 17150000.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 1620000.00 | 840000.00 |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 2983600.00 | 4209000.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 160400.00 | 160000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1850000.00 | 1850000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 318,100.00 | 280,000.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 145,600.00 | - |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 200,000.00 | 580,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 309,500.00 | 1,339,000.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | 25,546,700.00 | 7,497,584.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 126,700.00 | 120,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 24,728,100.00 | 6,686,584.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 691,900.00 | 691,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 899,200.00 | 15,600.00 |
| 210604 | Урсгал засвар | 899,200.00 | 15,600.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 628,600.00 | 248,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 628,600.00 | 248,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 832,800.00 | 1,497,800.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 508,800.00 | 1,173,800.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 324,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 9,200,000.00 | 30,660,400.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 24,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 9,200,000.00 | 6,660,400.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,034,500.00 | 3,493,495.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 14,034,500.00 | 3,493,495.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,234,500.00 | 3,243,495.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 800,000.00 | 250,000.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **13,466,080.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 13,466,080.00 |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 12,031,080.00 |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 1,435,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 511,570,300.00 | 528,837,500.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 486,201,100.00 | 507,447,300.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 486,201,100.00 | 507,447,300.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 25,369,200.00 | 21,390,200.00 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 25,369,200.00 | 21,390,200.00 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| 610002 | Төсвөөс гадуур байгууллага | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 33.00 | 33.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 20.00 | 20.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 8.00 | 8.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 4.00 | 4.00 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 144.00 | 144.00 |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 144.00 | 144.00 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 144.00 | 144.00 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **33.00** | **33.00** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 17.00 | 17.00 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 16.00 | 16.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Хангал сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Х.Тамжид танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд шилэн дансны хуулийн хэрэгжилтийг хангах, үндсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад анхаарах, батлагдсан төсвийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 29-наас 2021 оны 02 дугаар сарын 02-ны хооронд Булган аймаг дэх Төрийн аудитын газрын ахлах аудитор П.Содном хариуцаж хэрэгжүүлэв.

Хангал сумын ерөнхий боловсролын сургууль 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дэх Төрийн аудитын газарт 2021 оны 01 сарын 25-ны өдрийн 01/06 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### 3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Эрхэм зорилго : Булган аймаг Хангал Сумын Ерөнхий боловсролын сургууль нь

- Хүний хөгжлийн сайн сайханы төлөө
- Нэгж хичээлийн чанар өгөөжийг дээшлүүлнэ гэсэн эрхэм зорилтын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.
  Боловсролын тухай хуульд зааснаар Булган аймаг Хангал сумын Ерөнхий боловсролын Сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд
- Бүгдэд үр дүнтэй сургалтын орчин бүрдүүлэх
- Хүүхдэд ээлтэй дотуур байр хөтөлбөр
- Шатар дэд хөтөлбөр

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Боловсролын тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлт
- Монгол улсын засгийн газрын 151-р тогтоолын хавсралт

### 3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

### 3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлангийн зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн тайлангийн 425830.9 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 8516.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд өөрчлөх шаардлагагүй гэж үзлээ.

## 3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Хангал сумын сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 25745.4 мянган төгрөгөөр хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс бараа материал 26321.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хорио цээртэй холбоотой материал бага бэлтгэж эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

*Хүснэгт 1.* Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | | |
| Авлага | | | |
| Урьдчилгаа | | | |
| Бараа материал | 99319.6 | 72997.7 | -26321.9 |
| Үндсэн хөрөнгө | 599048.6 | 599625.1 | 576.5 |
| **Нийт хөрөнгө** | 698368.2 | 672622.8 | 25745.4 |
| Өр төлбөр | | | |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 698368.2 | 672622.8 | 25745.4 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | 698366.2 | 672622.8 | 25745.4 |

Мөнгөн хөрөнгө, авлага, өглөг дансны эхний болон эцсийн үлдэгдэлгүй байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 72997.7 мянган төгрөг болж 26321.9 мянган төгрөгөөр буурсан нь бараа материал 26321.8 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд хорио цээртэй холбоотой материал бага бэлтгэж эхний үлдэгдлээс зарцуулсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 599625.1 мянган төгрөг болж 576.5 мянган төгрөгөөр өссөн нь хичээл үйлдвэрлэлийн зардлаас тоног төхөөрөмж бэлтгэсэн, БУСГ-аас 3586.5 мянган төгрөгийн 2 компьютер ирсэн байна. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 13466.1 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн мянган төгрөгийн 3586.4 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

Үндсэн хөрөнгийн данснаас 25250.8 мянган төгрөгийн хөрөнгө акталж хасагдсан байна.

Биет бус хөрөнгө нь 1350.0 мянган төгрөгөөр өссөн нь санхүүгийн программ хангамж тайлант онд орлого авсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 672622.8 мянган төгрөг болж 25745.4 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн -55287.8 мянган төгрөг болж буурсантай холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан нягтлан бодох бүртгэлийн залруулга байхгүй байна.

## 3.6. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, ГҮЙЦЭТГЭЛ, НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТ

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 607071.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 607071.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 95501.1 мянган төгрөгөөр бууруулж 511570.3 мянган төгрөгөөр баталсан байна. Өмнөх оны төсвөөс цалинг 115971.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөл хийсэн нь төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл, шатлал ахих болон цалингийн нэмэгдүүлэхээр тооцжээ.

### Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх, хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 511570.3 мянган төгрөгийн төсөв баталснаас 486201.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс 25369.2 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс тогтмол зардлыг санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 507967.3 мянган төгрөгийн санхүүжилт авч, орон нутгийн төсвөөс 21390.2 мянган төгрөгийн нийт 529357.5 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 476082.2 мянган төгрөгийг зарцуулж 53275.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 476082.2 мянган төгрөг буюу 93.7 хувьтай байгаа нь цалингийн зардал 31086.7, тогтмол зардлыг 3478.5, норматив зардлаас хүнс 18041.5, үдийн цай 9991.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэн холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

### Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт санхүүжилтийн 520.0 мянга төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс хашааны хаалганы төмөрт 423.0, Шагжийн хөрөг хийх жаазыг 73.0 нийт 520.0 мянган төгрөгийг зарцуулжээ.

## 3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 272 мэдээллээс хугацаандаа оруулсан 272 мэдээлэл оруулж цахим хуудсанд бүрэн хөтөлсөн байна.

## 3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2331.9 мянган төгрөгийн зөрчилд 312.8 мянган төгрөгийн төлбөрийн акт, 891.2 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1127.9 мянган төгрөгийн албан шаардлагыг биелүүлсэн байна. Аудитаар өгсөн 891.2 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

*Хүснэгт 3* Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 1 | 312.8 | 1 | 312.8 | | | |
| Албан шаардлага | 1 | 1127.9 | 1 | 1127.9 | | | |
| Зөвлөмж | 1 | 891.2 | 1 | 891.2 | | | |
| Нийт дүн | 3 | 2331.9 | 3 | 2331.9 | | | |

## 3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 9180.5 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 121.6 мянган төгрөгийн зөрчилд 1 акт тогтоож, 7780.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 1350.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өглөө.

### Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай залруулга хийгдээгүй.

### Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 7830.5 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 121.6 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 7708.9 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүллээ. Үүнд:

1. Хичээл үйлдвэрлэлийн зардлаас тоног төхөөрөмж , хөрөнгө бэлтгэх 4989080, урсгал засварт 2719900, зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д "Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй", 6.4.1 дэх "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах," гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Албан шаардлага өгсөн.

2. БСУГ-ын даргын 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 01/317 дугаар албан бичгийн үндэслэн захирал Х.Тамжид 121657 төгрөгийн улирлын үр дүнгийн урамшууллыг авсан нь Төсвийн тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4 дэх " Үр дүнгийн гэрээний биелэлт, хэрэгжилтийн явц байдалд үндэслэн үр дүнгийн гэрээг дүгнэх эрх бүхий этгээд нь дараах арга хэмжээг авна:", 40.4.2 дахь "хуульд заасан бүрэн эрхийнхээ хүрээнд урамшуулах, хариуцлага тооцох", Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 1.2.1. "төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид;" заалтуудыг тус тус зөрчсөн байна.

<u>Шийдвэрлэсэн нь:</u> Төлбөрийн акт

### Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 1350 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

## 3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

## 4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

*Удирдлагатай холбоотой асуудал*

1. *Илрүүлэлт:* Байгууллагын дотоод журмыг байгууллагын даргын 2018 онд баталсныг Төрийн албаны болон бусад хууль тогтоомж шинэчлэн гарсантай холбоотой өөрчлөлтүүд хийгээгүй нь Хөдөлмөрийн тухай хуулийн 130 дугаар зүйлийн 130.1 дэх "Ажил олгогч нь ажилтны төлөөлөгчдийн саналыг харгалзан хөдөлмөрийн дотоод журмыг хууль тогтоомжид нийцүүлэн баталж мөрдүүлнэ." гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

1.1. *Эрсдэл:* Хууль, журам зөрчигдөх

*1.2. Өгсөн зөвлөмж:* Байгууллагын дотоод журмыг Төрийн албаны болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн шинэчлэн батлуулах.

*1.3. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:*

*2. Зардлын данстай холбоотой асуудал*

*2.1. Илрүүлэлт:* Мэдээлэл технологийн зардлаас Нягтлан бодох бүртгэлийн программын хөгжүүлэлт хийгдэх 4 жилийн гэрээний дагуу 1350.0 мянган төгрөгийн программ хангамжийг орлогоор бүртгээгүй.

*2.2. Эрсдэл:* Хөрөнгө дутагдах, хууль журам зөрчилдөх.

*2.3. Өгсөн зөвлөмж:* Үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, бараа материалыг анхан шатны баримтад үндэслэн хөдлөл, өөрчлөлтийг тухай бүр хийж, байх.

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР Ж.ЭНХЦООДОЛ

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР П.СОДНОМ